



## МОНГОЛЫН УЛАМЖЛАЛЫН НЭГДСЭН НАМЫН 2008 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

### ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

МУНН-нь Монголын ард түмний олон зууны турш бүтээсэн хосгүй соёл иргэншил, нэн ялангуяа төр ёсны түүхэн уламжлалыг бүтээлчээр өвлөн хөгжүүлж авсан намын хувьд улс орноо хөгжүүлэх, удирдахдаа монголын аугаа их төрийн ухааныг орчин үеийн шинжлэх ухааны ололттой бүтээлчээр хослуулан төрийн бодлогод тусган хэрэгжүүлэх үйлсийг намынхаа мөрийн хөтөлбөрийн түүхэн зорилт гэж үзнэ.

### Нэг. Улс төрийн хүрээнд

1.1. Төрийн засаглалын хэлбэрийн зохистой сонголт шийдлийн хүрээнд Монгол төрийн түүхэн уламжлалыг үндэс болгон Ерөнхийлөгчийн засаглалын хэлбэрийг тууштай сонгон хэрэгжүүлнэ.

1.2. Монгол хүн Монгол газар шороондоо эзэн байх зарчмыг Монгол төрийн бодлогын тулгуур үндэс болгон эзэн зочны харьцааг байр байранд нь байлгах эрх зүйн орчинг бий болгон, Үндэсний эрх ашгийг дээдлэх зарчмыг Монголын төрд төлөвшүүлнэ.

1.3. Монгол Улсын бодитой оршин тогтнохын үндэс болсон хүн амын эрүүл өсөлт, нийгмийн баталгааг төрийн бодлогоор түлхүү дэмжиж, хүнрүү чиглэсэн, хүн төвтэй төрийн бодлогыг тууштай хэрэгжүүлэхийг тэргүүн зэргийн зорилго болгоно.

1.4. Монголоо гэх үнэн сэтгэлтэй, өндөр боловсролтой, оюунлаг хүмүүсээр төрийн албыг бэхжүүлэн, төрийн албан тушаалд яс үндэс, шашин шүтлэг, намын харъяаллыг үл харгалзан ажиллуулах зарчмыг тууштай хэрэгжүүлнэ.

1.5. Нутгийн өөрөө удирдах ёсыг жинхэнэ утгаар хэрэгжүүлж, Монгол Улсыг бүсчилэн хөгжүүлэх замаар засаг захиргааны үндсэн нэгжүүдийг нэгтгэн, эдийн засгийн хараат бус байдлаар зохион байгуулж, орон нутгийн засаг захиргааны нэгжүүдийн эрх мэдлийг бодитойгоор нэмэгдүүлж, бие даан хөгжих таатай нөхцөл бүрдүүлнэ.

1.6. Хүний эрх, эрх чөлөө, хууль ёс, уламжлал соёлоо дээдэлсэн бодлогыг Монгол төрийн бодлого болгон төлөвшүүлнэ.

1.7. Хууль тогтоох гүйцэтгэх болон шүүх засаглалын үйл ажиллагааны харилцан хамаарал, эрх мэдлийн зохистой тэнцэл, хувиарлалтын зарчмыг шинэчлэн, тэдгээрийн эрх зүйн хэм хэмжээг шинээр бий болгоно.

1.8. Шүүх засаглалын нэгдмэл тогтолцоо бүрдүүлж, бие даасан хараат бус байх зарчмыг үндэс болгосон хууль дээдлэх зарчмыг бүх шатанд чанд хэрэгжүүлнэ.

1.9. Авилгал, хээл хахуулийн сүлжээг таслан зогсоож, түүнд холбогдсон төрийн албан тушаалтнуудад хуулийн хатуу хариуцлага хүлээлгэдэг эрх зүйн орчин бүрдүүлнэ.

1.10. Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг жинхэнэ утгаар хэрэгжүүлж, дөрөв дэх засаглал тунхаглалаас бодит хүчин зүйл болгон төлөвшүүлнэ.

1.11. Гадаад дахь элэг нэгт Монгол ахан дүүстэйгээ харилцах харилцааг шинэ түвшинд гаргаж, тэдний Монголд ирж Монгол хүний ёсоор ажиллаж амьдрах хууль эрх зүйн орчинг бий болгоно.

### Хөёр. Эдийн засгийн хүрээнд

2.1. Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн нэгдсэн концепцийг нөхөн сэргээгдэх баялаг дээр тулгуурласан Монгол хүний чаддаг зүйл дээр суурилсан байх ёстой гэж үзнэ.



2.2. Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг аялал жуулчлал, мал аж ахуйн салбарт чиглүүлэн түүний дэд бүтцийг төсвийн хөрөнгө оруулалт болон хандивлагчдын зээл тусламжаар санхүүжүүлнэ.

2.3. Бүс, аймаг, сум, багийн төвүүд дээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд бүх шатны боловсруулалт хийх жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулж, татвар, гаалийн таатай орчинг бүрдүүлнэ.

2.4. Ажлын байр шинээр бий болгох, ядуурлыг бууруулах үүднээс Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг 5-10 жил бүх төрлийн татвараас чөлөөлөх эрх зүйн орчинг бий болгож, аялал жуулчлалын салбар болон малчдыг бүх талаар хөхүүлэн дэмжих цогц бодлого авч хэрэгжүүлнэ.

2.5. Гааль, татварын бодлогыг Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн хөшүүрэг болгох чиглэлийг баримтлан энэ талын эрх зүйн орчинг өөрчилнө.

2.6. Татварыг бүс нутгаар ялгавартай тогтоож, орон нутагт ажиллаж амьдрах нөхцөлийг татварын бодлогоор дэмжинэ.

2.7. Эдийн засаг, бизнесийн орчинд төрийн оролцоог багасгаж, төрийн зүгээс бизнест үзүүлж буй дарамт шахалтыг үгүй болгосноор хөдөлмөрийн үнэлгээ цалин, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх орчинг бүрдүүлнэ.

2.8. Стратегийн ач холбогдолтой эдийн засгийн салбаруудад төрийн оролцоо, зохицуулалтыг бий болгон төр мэдэлдээ байлгах зарчим баримтална.

2.9. Газар болон газрын хэвлийн баялагийг зөвхөн Монгол хүн эзэмших, ашиглах эрх зүйн орчинг бий болгоно. Зөвхөн Монгол хүнээр дамжиж эдийн засгийн эргэлтэд оруулна.

### **Гурав. Нийгмийн хүрээнд**

3.1. Хүн ардынхаа амьдралын чанарыг эрс дээшлүүлэх нь төрөөс нийгмийн өмнө хүлээх гол үүрэг гэж үзнэ.

3.2. Эхчүүдэд төрүүлсэн хүүхдийн тоог харгалзан өсгөн нэмэгдүүлэх тэтгэмж олгох тогтолцоог бий болгож, монгол хүн амын өсөлтийг хөхүүлэн дэмжих төрийн бодлого хэрэгжүүлнэ. (Гуравдах хүүхдээс эхлэн сар бүр 100 мянган төгрөг, түүнээс дээш өсгөн нэмэх тэтгэмж улсаас өгч, зургаагаас дээш хүүхэд төрүүлсэн эхэд 5 сая төгрөг, наймаас дээш хүүхэд төрүүлсэн эхэд 10 сая төгрөг олгох, сургалтын зардлыг төр хариуцаж, орон сууцны төлбөрт хөнгөлөлт үзүүлэх)

3.3. Залуучуудыг гэр бүл болох, орон сууц худалдан авах, бизнес эрхлэх, сурч боловсроход зориулж төрөөс урт хугацаатай зээл олгох бодлого хэрэгжүүлнэ.

3.4. Эрүүл мэндийн даатгалын системийг тууштай нэвтрүүлж, хүн амыг үнэ төлбөргүй эмчлэх, эрүүл аж төрөх, боловсрол хүмүүжлийг дээшлүүлэхэд анхаарна.

3.5. Хөдөөгийн хөгжлийг дэмжсэн улс, нийтийг хамарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.6. Орон сууцны хувьчлалд хамрагдаагүй гэр хорооллынхонд нөхөн төлбөр өгч, хямд өртөгтэй, тохилог хувийн сууц барих төслийг төрөөс ивээн тэтгэнэ.

### **Дөрөв. Боловсрол, соёл, шинжлэх ухааны хүрээнд**

4.1. Шинжлэх ухааныг хөгжлийн хөтөч хэмээн үзэж, оюуны амжилт, нээлт бүрийг хөхүүлэн дэмжих бодлого барина.

4.2. Ерөнхий боловсролын сургалтыг орчин үеийн нийгмийн шаардлагад нийцсэн түвшинд хүргэнэ.

4.3. Мэргэжлийн ажилчин бэлтгэх сургууль, курсийг олноор бий болгоход төрөөс дэмжиж, өндөр мэргэжилтэй ажилчин бэлдэх, тэднийг үйлдвэрлэлтэй холбоход гол анхаарлаа хандуулж ажиллана.

4.4. Монгол туургатны их сургууль шинээр байгуулж түүх, соёл, зан заншлаа судлан сэргээх бодлого хэрэгжүүлж, Монгол төрийн боловсон хүчнийг шинээр бэлтгэнэ.



- 4.5. Хүүхэд залуучуудын дунд ахмад үеэ хүндэтгэдэг, түүх, соёл, уламжлал, ёс төрөө дээдлэх хүмүүжил олгоход онцгой анхаарч боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт оруулна. Монголын түүх, монголын уран зохиол, монгол хэлний үнэлэмжийг дээшлүүлж, бүх шатанд суралцах, төрийн албанд ажиллахад монгол хэл, монголын түүхийн мэдлэгээр шалгалт авдаг болгоно. .
- 4.6. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарыг сэргээн хөгжүүлэх төрийн бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 4.7. Монгол төр хүн ардынхаа сэтгэлийг ариусган, хүмүүнлэг, энэрэнгүй зан суртахууныг төлөвшүүлэхэд уламжлалт ардын ёс, шашнаа түшиглэн, түүний шинэчлэлтийг дэмжих нь нийт ард түмний эрх ашиг гэж үзнэ.

#### **Тав. Байгаль орчны хүрээнд**

- 5.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэлхийн шим мандлын олон улсын тусгай бүс байх чиг бодлогыг баримтлан олон улсын дэмжлэг авах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулна.
- 5.2. Монгол орны онгон сайхан байгальг хамгаалах, зүй зохистой ашиглах хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. Байгал орчинд сөрөг нөлөө үзүүлэх бүх үйлдлийг таслан зогсооно.
- 5.3. Хүний зохисгүй харьцаанаас болж байгальд учруулсан хор хохирлыг багасгах, байгальд нөхөн сэргээлт хийх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулна.
- 5.4. Монгол оронд нүүрлээд байгаа цөлжилтийг зогсоох талаар эрдэм шинжилгээний болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

#### **Зургаа. Үндэсний аюулгүй байдлын хүрээнд**

- 6.1. Монгол Улсын тусгаар тогтнолын баталгааг Монгол Улсын газар нутгийн бүрэн бүтэн байдал, түүн дээр амьдрах Монгол үндэстний хүн амын өсөлт гэж үзнэ.
- 6.2. Өндөр хөгжилтэй хүчирхэг гүрнүүдийн байнгын сонирхолыг буй болгож урд хойт хоёр хөрштэйгээ тогтоосон уламжлалт найрсаг харилцаанд түлхүү анхаарна.
- 6.3. Монгол Улсын Зэвсэгт хүчний шинэчлэлийг бүх талаар явуулж, улс орноо батлан хамгаалах номлол, төрийн цэргийн бодлогыг шинэчлэнэ.
- 6.4. Монгол Улс төвийг сахисан, нээлттэй эдийн засагтай орон байх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 6.5. Монгол Улсын хөгжлийн хэтийн төлөвийг түүх, соёл, уламжлал, мал аж ахуй, онгон байгалиа түшиглэсэн аялал жуулчлалын салбарын хөгжил гэж үзнэ.
- 6.6. Улс орны нэгдмэл байдлыг хангах үүднээс ирээдүйд шашин хоорондын мөргөлдөөн гарахаас сэрэмжилж, уламжлалт шашин мөргөлийн зан үйлийг түлхүү хөгжүүлж, бусад шашныг зочны хэмжээнд байлгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 6.7. ОХУ-тай тогтоосон уламжлалт ах дүүгийн найрамдалт харьцааг сэргээхэд онцгой анхааран, эрх тэгш харилцан ашигтай байх зарчим баримтална.

#### **МУНН-ын туйлын зорилго**

*Биеэ даасан бодлого явуулдаг олон сая хүн амтай, онгон сайхан байгальтай, уламжлал, түүх, соёлоо дээдэлдэг, хүчирхэг, баян тансаг Монгол Улсыг буй болгож түүний тогтвортой хөгжих нөхцлийг бүрдүүлэхийг туйлын зорилгоо гэж үзнэ.*